

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№19/496

ШУС, НУС

2018

“ИНТЕРНЕТ НЭМЭХ” ЦАГ ҮЕ ДЭХ ЗОХИОГЧИЙН ЭРХ ЗӨРЧСӨН ХУЛГАЙН ХЭВЛЭЛ ҮҮССЭН ҮЗЭГДЛИЙН ШАЛТГААН БОЛОН ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА, АРГА ХЭМЖЭЭГ ШИНЖЛЭХ НЬ

Ду Сянжуй*, Жү МэйХэ**

*БНХАУ, ӨМИС-ийн Уран Зохиол, Сэтгүүл Зүйн Дээд Сургууль

**БНХАУ, Хятадын Улс Төрийн Шинжлэх Ухаан ба Хууль Зүйн Их Сургуулийн Сэтгүүл зүй ба харилцаа холбооны дээд сургууль

Түлхүүр үг: “интернет нэмэх”, зохиогчийн эрх зөрчсөн хулгайн хэвлэл, шалтгаан, хариуцлага.

Оршил. “Интернет нэмэх” (интернет нэмэх буюу хятадаар 互联网+ хэмээх нэр томъёог БНХАУ-ын Төрийн зөвлөлийн сайд Ли Кэцян санал болгосон бөгөөд энэ нь аж үйлдвэржилтийн IV хувьсгал, мэдээллийн эрин зуун гэдэгтэй ижил ойлголт юм) бол оюун мэдлэгийн нийгмийн шинийг сэдэх, энэ үеийн хөгжлийн хүчээр эдийн засаг, нийгэм хийгээд интернет сүлжээний хэлбэр маяг тасралтгүй улиран өөрчлөгдсөний үр дүн мөн. Түүний мөн чанар бол интернет хийгээд уламжлалт ажил төрлийн уялдаа холбоо юм. Гэхдээ интернет хийгээд хэвлэлийнхний уялдаа холбооноос үүссэн “зохиогчийн эрх зөрчсөн хулгайн хэвлэл”-ийн асуудал нь интернет нэмэх үед шинэ маягийн онцлогтой байгаа тул хэвлэлийнхний чухалчилж үзэх ёстой асуудал болоод байна. Тус өгүүлэл нь БНХАУ-ын “Порнограф болон хууль бус хэвлэл мэдээллийг эсэргүүцэх”

албан гэр ба Үндэстний зохиогчийн эрхийг хамгаалах байгууллагаас нийтэлсэн зохиогчийн эрх зөрчиж хэвлэл хулгайлсан кэйсүүдэд анализ хийж, энэхүү судлагдахуун доторх “хэвлэл хулгайлах” ажиллагааг шинжлэхдээ түүний онцлог, буй болсон шалтгаан, түүний хариуцлага зэрэг асуудлуудыг илрүүлэхийг зорив.

“Интернет нэмэх”-ийн мөн чанар бол интернет болон уламжлалт ажил төрлийн хоорондох уялдаа болно. Хэвлэн нийтлэгчид “интернет нэмэх” сэтгэхүйг ашиглан, интернет ба уламжлалт хэвлэлийг уялдуулснаар шинэ боломжууд бий болж буйд баярлууштай. Гэвч зохиогчийн эрхийг зөрчиж, хэвлэл хулгайлагчид цэгээс цэг хүрэх технологийг (point-to-point technology) эзэмшсэн мөртөө төвлөрлийг сааруулах нөлөөний дагуу зохиогчийн эрхийг зөрчиж хэвлэл хулгайлах асуудал нь манай нийгмийн мэдээллийн сүлжээнд (онлайн) төвлөрчээ. Зохиогчийн эрх нь зөрчигсдийн ихэнх нь сүлжээний үйлчилгээ үзүүлэгч байж, тэдгээр нь Хятадын зүүн хэсэгт төвлөрдөгөөр барахгүй тэндээс сүл-

жээний (онлайн) нийтлэл олон гардаг онцлогтой юм. “Интернет нэмэх” цаг үе дэх зохиогчийн эрх зөрчсөн хулгайн хэвлэлийн асуудал буй болсны шалтгаан нь техник технологийн хөгжил, үлэмж их ашиг хонжоо, улсаараа ном унших уриалга, хуваалцах үзэл ойлголт хийгээд зохиогчийн эрхийн системийн дутагдал зэрэг шалтгаан юм. Үүнээс гадна, тус өгүүлэлд эрхийг нотлон тогтоох жич эрх ашгийг хамгаалах шинэ арга хэмжээг ашиглах, хулгайн хэвлэлийг эсэргүүцэхийг улам сонирхолтой болгох, хууль цаазын системийг төгөлдөржүүлэх ба зарчмуудыг салган хэрэглэх зэрэг хариуцах аргуудыг тусгасан юм.

Нэг. Зохиогчийн эрхийг зөрчсөн хулгайн хэвлэлийн онцлог

“Интернет нэмэх”-ийн онцлог нь сүлжээний нийтлэлд төвлөрч байна. Манай улсын 2016 онд засварласан “Хэвлэлийн хамааралтын дүрэм тогтоол” ба 2016 онд хэрэгжүүлсэн “Сүлжээний хэвлэлийн үйлчилгээний хамааралтын тогтоол”-ыг үндэслэвэл, хэвлэл нийтлэлийг дотор нь сонин, сэтгүүл, ном бичиг, дүрс бичлэгийн бүтээгдэхүүн, электрон хэвлэл ба сүлжээний нийтлэл хэмээх 6 төрөлд ангилж болно. Үүнд сүлжээний нийтлэлд эрхийг зөрчсөн хулгайн хэвлэл гарах тохиолдол бараг 43.4%-ийг эзэлдэг. Энэ нь интернетийн цаг үе дэх эрхийг зөрчсөн хулгайн хэвлэлийн цаг үеийн онцлогийг харуулахаас гадна манай улсын интернетийн хэрэглэгчдийн зохиогчийн эрхээ хамгаалах үзэл ухамсар сул байгаагийн илрэл юм. Бидний судалгаанд багтсан жишээнээс үзвэл, эрхийг зөрчиж хэвлэл хулгайлсан нийтлэлд сүлжээний тоглоом, кино, комик ч багтдаг. Жишээлбэл, Анхүй мужийн Тэн овогтноос “Legend Of Mir”

тоглоомын ховын сервер нээж ашиг олсон, Шанхайн “Shooter” сайт нь эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр “Лууг хэрхэн сургах вэ” зэрэг кино бүтээлүүдийг нийтэлснээс болж Америкийн киноны нийгэмлэг зарга үүсгэсэн, “Жү Жү комик” зэрэг сайтууд зохиогчийн эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр “Slam Dunk”, “Naruto”, “One Piece” зэрэг 351 комик бүтээлүүдийг сайтдаа нийтэлсэн зэргийг дурдаж болно. Ерөнхийд нь үзвэл, эрх зөрчсөн хулгайн хэвлэл нь голдуу сүлжээний нийтлэлд төвлөрч буй. Гэхдээ ном бичиг, электрон хэвлэлд зохиогчийн эрх зөрчиж хэвлэл хулгайлсан хэргийн тоо хоёрдугаарт орж, 26.4%-ийг эзэлжээ. Жинхэнэ хэвлэлийн ном бичиг, электрон хэвлэлийн хэвлэх өртөг нэмэгдсэн, бас зах дэлгүүрийн хэрэгцээ нь сүлжээний нийтлэлд нөлөөлснөөс болж эрх зөрчсөн хулгайн хэвлэлийн ном бичиг, электрон хэвлэлд далимдуулах орон зайг олгожээ.

Хоёр. Эрх зөрчсөнөөс үүдэн хариуцлага хүлээгсдийн ихэнхи нь сүлжээний үйлчилгээ үзүүлэгч

“БНХАУ-ын иргэний эрх зөрчсөн хариуцлагын тухай хууль”-д эрх зөрчсөн гол хариуцлагатны тухай онцгой тогтоолд зааснаар, сүлжээний үйлчилгээ үзүүлэгчээс хэрвээ сүлжээг ашиглан бусдын иргэний эрх ашгийг хөндөхөд хүрвэл эрх зөрчсөн этгээд хариуцлага хүлээх үүрэгтэй байдаг. Тус өгүүлэлд илэрсэн эрх зөрчсөн хариуцлагатнуудын ихэнх нь сүлжээний үйлчилгээ үзүүлэгч байлаа. Тэдний дотор байгууллага, хувь хүн, групп багтаж буй. Энэ удаагийн судлагдахуунд хамрагдсан хэргийн жишээнээс үзвэл, сүлжээний үйлчилгээ үзүүлэгчээс эрхийг зөрчсөн гол хариуцлагатан болсон тоо 24-т хүрсэн

нь 48%-ийг эзэлжээ. Жишээлбэл, “Qvod” компани, “Бай Дү” компаниас тодорхой чиглэл хайлт, тодорхой чиглэлт холбоосоор дамжуулан олон нийтийг их хэмжээний хулгайн хэвлэлийн сайт руу хөтөлсөн байна. Энэ нь мэдээллийн сүлжээний дамжуулгын эрх зөрчсөн үйл ажиллагаа мөн. Үүнээс гадна хувь хүн буюу группээс сүлжээний тоглоомуудад хувийн сервер угсрахаар дамжуулан ашиг олсон нь мөн эрх зөрчиж хэвлэл хулгайлсан жишээ юм. Манай улсад интернет дэх хэвлэлийн эрхээ хамгаалах үзэл ухамсар дутмаг байдаг ба сүлжээний үйлчилгээ үзүүлэгчдээс технологийн дөхөм үзүүлдэг ийм дотоод гадаад хүчний нөлөөн доор эрх зөрчсөн хулгайн хэвлэл үүсэх нөхцөл бүрдсэн байна.

Гурав. Сүлжээний нийтлэл Хятадын зүүн хэсгээр төвлөрч голлосон

Бидний судлагдахуун (судалгааны объект)-аас үзвэл, ойрын 5 жилд эрх зөрчсөн хулгайн хэвлэлийн хэрэг олноор гарсан газар нь Хятадын зүүн хэсэгт төвлөрч буй. Үүнд Жан Сү, Шандун, Анхуй, Шанхай зэрэг муж хот нь тэргүүн байранд орж байна. Тус дөрвөн хот, мужид эрх зөрчсөн хулгайн хэвлэлд сүлжээний нийтлэл давамгайлж, Жан Сү-д зургаа гарсан нь тус мужийнхаа 67% -ийг, Шанхай-д гурав тохиолдсон нь тус хотынхоо 75%-ийг, Анхуй-д хоёр тохиолдсон нь тус мужийнхаа 33%-ийг, Шандун-д дүрс бичлэгийн бүтээгдэхүүн их, гэхдээ мөн гурав тохиолдсон нь тус мужийнхаа 43%-ийг эзэлжээ. Хятадын зүүн хэсгийн газар орны эдийн засаг, технологи хөгжсөн мөртөө хулгайн хэвлэлийн зах дэлгүүр дэх дотоод гадаадын хэрэгцээ их байх зэрэг нь сүлжээний нийтлэлд эрх зөрчсөн хулгайн хэвлэл

гаргахад маш дөхөм нөхцөл үзүүлжээ. Жишээлбэл, Жан Сүгийн “Limanhua” сайт нь эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр сүлжээний дээр их хэмжээний эрх зөрчсөн хулгайн хэвлэлийн комик бүтээлүүдийг цасан, Шанхайн Чин Шэн сүлжээний технологийн хязгаарт компанийн “Echo” хэмээх аппликэйшнаас хэрэглэгчдэд “Болзоо” зэрэг хөгжмийн бичлэгүүдийг сүлжээнд байрлуулж, төлбөртэй үйлчилгээ үзүүлсэн зэрэг хэргүүдийг дурдаж болно.

Дөрөв. Эрх зөрчсөн хулгайн хэвлэл үүссэний шалтгаан: Интернет нэмэх нь хэвлэн нийтлэгчдэд боломж бас сорилтыг авчирч байна

1. Эдийн засгийн үүднээс: Технологийн хөгжил хийгээд ашиг хөөцөлдсөн сонирхол

Эдийн засгийн хөгжил нь интернетийн технологийн хөгжлийг ахиулсны дагуу, төвлөрлийг сааруулах онцлогтой point-to-point технологийг өргөнөөр хэрэглэхэд хүргэсэн ба интернет хэрэглэгчдийн тооцооллын хүчин ба битийн хурдыг түшиглэснээр эл төрлийн эрх зөрчсөн хулгайн хэвлэлийн нийтлэлийг олоход улам дөхөм болжээ. Үүний хажуугаар хэвлэл мэдээллийн хэлбэр олон янзтай болж, бусдын бүтээлд хуулбар хийхэд олон зүйлийн сунгалт олсон нь хэвлэл хулгайлахад хялбар болсноор барахгүй хулгайн хэвлэлийн өөрийн өртгийг багасгажээ. Цаасан хэвлэлийн ном бичгийн хулгайн хэвлэлийг хийх өртөг нь сүлжээний нийтлэлээс өндөр байж, хуулбар хийх, зөөвөрлөхөд нэлээд олон хүний хүч хөдөлмөрийг шаарддаг. Харин сүлжээний нийтлэлийн эрх зөрчсөн хулгайн хэвлэлд цэгээс цэг хүрэх (point-to-point) технологийг өргөн ашигласнаар, бүр мөсөн төлбөргүйгээр буюу бага зэргийн

мөнгө зарцуулан оруулах буюу татах аргаар сүлжээний нийтлэлийг олж болдог. Ийм байдалд сүлжээний хэрэглэгчид ба сүлжээний үйлчилгээ үзүүлэгчид амархан эрх зөрчсөн гол хариуцлагатан болдог юм.

2004-2008 онуудад Жин Бо Цүн, Ху Бо нар ажлынхаа боломжийг ашиглан үйлдвэрлэлд хэрэглэдэг хэмжих компьютер машины хяналтын прог-рамм хангамжийг нууцаар декод хийж хуулбарлан авжээ. Тэд удалгүй тус үйлдвэрээс гарч, Гуан Дүн мужийн Дүн Гуан хотод Шүн Лин нэрэмжит машины үйлдвэр нээж, Чан Жү хотын Фан Миний нэрэмжит электрон тоног төхөөрөмжийн үйлдвэрээс зохиогчийн эрх эзэмшсэн хэмжих компьютер машиныг зөвшөөрөлгүйгээр үйлдвэрлэж, Гуан Дүн, Шан Дүн, Жэ Жан, Хэ Нан зэрэг мужуудад борлуулснаар нийт 5 сая юаний ашиг олсон байна. Сүүлд Жан Сү мужийн Чан Жү хотын цагдаагийн газрын Амрыг хамгаалах ангийнхны нягт мөрдөн байцааснаар зохиогчийн эрх зөрчиж хэвлэл хулгайлсан сэжигтэн Жин Гүэ Цүн, Хү Бо хоёрыг баривчлан, тэднийг Шүүх хороонд тушаан ял оноон мөнгөн торгуулиар шийтгэсэн байна. Интернет техноло-гийн хөгжлийн дагуу хулгайн хэвлэлийн сүлжээний нийтлэлийн өөрийн өртөг нь жинхэнэ хэвлэлийн сүлжээний нийтлэлээс хямд учир хулгайн хэвлэлийн сүлжээний нийтлэлийн үнэ хямдарсан нь жинхэнэ хэвлэл нийтлэлийн зах зээлд асар их хохирол учруулжээ. Эсрэгээр хулгайн хэвлэлийн хямд үнэ нь хүмүүсийн худалдаж авах сонирхлыг нэмэгдүүлсэн нь хулгайн хэвлэлийн зах зээл тэлэхэд нөлөөлжээ. Харин засаг жинхэнэ хэвлэлийнхнээс хулгайн хэвлэлд цохилт өгөх ажиллагаа явуулахад эдгээр нь бүтээгдэхүүнийхээ өөрийн

өртөгт багтаж орох болохоор жинхэнэ хэвлэлийн нийтлэлийн үнэ өсдөг юм.

2. Соёлын үүднээс: Улсаараа ном унших уриалга ба хуваалцах үзэл ойлголт

2006 онд улсаараа ном унших арга хэмжээ явагдсанаас өнөө бүх улсын эл газрынхан зохих амжилт олсон байна. Илэрхий үзэгдлээс хэлэхэд эмнэлэгт ном худалдах автомашинууд байршиж, далд үзэгдлээс хэлэхэд бүхий л хүмүүсийн боловсрол алхам алхмаар дээшилжээ. Интернет технологийн хөгжлийн дагуу эл төрлийн уламжлалт хэвлэл нийтлэл нь интернетийг ашигласнаар сүлжээний нийтлэл руу шилжжээ. Харин сүлжээний нийтлэл нь хүмүүсийн богино хугацааны цагийг нөхдөг болохоор аяндаа богино хугацааны уншлага буй болсон учиртай. Бээжингийн Тянь Ин Жө сүлжээний технологийн хязгаарт компани нь эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр өөрийн эзэгнэж байсан “Ifeng” сайтаар “Apple” гар утсаны хэрэглэгчийн программ хангамжаараа “Дундад Вьетнамын дайны нууц тэмдэглэл” гэх номыг дамжуулснаар уншигчдын тоо өсч, өргөн тархжээ. Хүмүүсийн амьдралын айзам хурдац ч, бас богино хугацааны уншлага нь хүмүүст мэдлэг түргэн нэмэгдэх буруу төөрөгдөл олгодог болсноор их олон хүнийг мэдлэгийн түгшүүр бодолтой болгожээ. Үүнээс гадна улсаараа ном уншихыг уриалж байгаа орчин дотор хүмүүсийн ном унших, сүлжээний нийтлэл унших хэрэгцээ нэмэгдсэнээр сүлжээний нийтлэлийн зах зээлийн хэрэгцээ бас өссөн нь эрх зөрчсөн хулгайн хэвлэлийн нийтлэлд зах зээлийн орон зай ба боломж олгосон байна.

Өнөөгийн “хуваалцах аж ахуй”-н сэтгэхүйн зогсоцоос харсан ч, уламжлалт ёс суртал дахь “хуваалцах” үзэл

ойлголтоор ойлгосноор ч манай улсын хүмүүсийн “хуваалцах” үзэл ойлголт бол аль эртнээс буй болсон бат бэх үндэс суурьтай юм. Гэхдээ энэхүү “хуваалцах” сэтгэхүйг ашиглан, эдийн засгийн ашиг тусын зогсоц буюу энгийн хуваалцах үзлээс болж зохиогчийн эрх бүхий эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр түүний бүтээлийг “хуваалцах” нь нэгэнт зохиогчийн эрх зөрчсөн үйл ажиллагаанд тооцогдох болжээ. Гэхдээ энд сургалт, эрдэм шинжилгээний ажилд онц зөвшөөрөлтэйгээр хуваалцах тохиолдлыг оруулаагүй болно. Урьд нь “legend” хэмээх тоглоом трэнд болж байхад зарим хүмүүс хувийн сервер байгуулан бусадтай тоглоомыг хуваалцсан нь нэг ёсны жишээ мөн.

3. Хууль цаазын тал: Зохиогчийн эрхийн систем дэх дутагдал

“Зохиогчийн эрхийн хууль” батлагдсан нь манай улсын зохиогчийн эрхийн систем жинхэнээр байгуулагдсаны илрэл мөн. Гэвч манай улсын зохиогчийн эрхийг хамгаалахаар тогтоосон хуулийн буй болсон цаг нь орой мөртөө гол төлөв өрнө дахины улс хийгээд олон улсын оюуны өмчийн хамаа бүхий нийтийн гэрээний эсрэг буй болсон болохоор хэд хэдэн удаа өөрчлөгдсөн боловч мөн зохицох чанараар муу, идэвхи чанар нь сул байсаар ирсэн. Иймээс тус системд зохих хэмжээний дутагдал оршсоор байна. Жишээлбэл, манай улсын Зохиогчийн эрхийн хуульд зохиогчийн эрх зөрчсөн үйл ажиллагааны хариуцлагын тухай дүрэм тогтоол гаргасан боловч хариуцлагаас зугатсан тохиолдолд тодорхой тогтоол гаргасангүй. Иймээс зохиогчийн эрх зөрчсөн хариуцлага нь “Иргэний хуулийн ерөнхий дүрэм”-д тогтоосон “Ослын хариуцлага”-ын дагуу шийдэгддэг хэрнээ дахин иргэний хэргийн (заргалдааны) зарчим болох “Хэн

баримталбал хэн гэрч үзүүлэх” зарчимтай уялдуулбал, нэхэмжлэгчээс заавал шүүгдэгчийн тал дээр эрх зөрчиж хэвлэл хулгайлсан осолтой болохыг зааж гаргасан нөхцөлд л шүүгдэгчээс холбогдсон иргэний хэргийн хариуцлагыг үүрэглэдэг юм.

Гэхдээ хэвлэлийн эрх бол биет бус хөрөнгөд багтдаг учраас шүүгдэгч талын хувьд эрх зөрчиж хэвлэл хулгайлсан эсвэл осол байх эсэхийг ялгахад хэцүү байдаг билээ. Тус өгүүллийн судалгааны жишээнээс үзвэл, Анхуйн “Сү Жөгийн (9.27) сүлжээний дээр хулгайн хэвлэлийн нийтлэл борлуулсан хэрэг”-ийг илрүүлэн баривчлахаас эхлэн шүүх хорооноос ял оногдуулах хүртэл урьд хожид нэг жилийн хугацаа зарцуулжээ. Бас Анхуйн “Тэн овогт зэрэг хүмүүс сүлжээний тоглоомын зохиогчийн эрх зөрчсөн хэрэг” нь дансалснаасаа ял оногдуулах хүртэл нэг жил, таван сарын хугацаа зарцуулсан байна. Илрүүлэн данслахаас ял оногдуулах хүртэл зарцуулах хугацаа урт байгаа нь уламжлалт шүүн таслах явц яршиг ихтэй байдгаас барахгүй манай улсын зохиогчийн эрх зөрчсөн хариуцлагад тохирдог “Ослын хариуцлага” нь шүүгдэгч талын хувьд эрх зөрчиж хэвлэл хулгайлсан нь орших эсэхэд гэрч авахад хүчир мөртлөө гэрч авах цаг нь урт байдгаас шалтгаална.

Тав. Эрх зөрчсөн хулгайн хэвлэлийг эсэргүүцэх нь: Цаг үетэйгээ тохируулж тасралтгүй төгөлдөржүүлэх шаардлагатай

1. Эрх нотлон тогтоох, эрх ашгийг хамгаалах шинэ маягийн хэрэгслийг ашиглах

Сүлжээний нийтлэлийг нийтлэхээс өмнө эрхийг нотлон тогтоох бол зохиогчийн эрхийг хамгаалахад юуны өмнө хийх зохистой ажил болно. Олны

мэдээж байгаачлан уламжлалт хэвлэл нийтлэлийг нийтлэхээс өмнө урьдаар газар орны зохиогчийн эрхийн байгууллагаас шалган бүртгэж, дараа нь үндэстний зохиогчийн эрхийг хамгаалах төвөөс шалган, үндэстний зохиогчийн эрхийн байгууллагаас бүртгэдэг болохоор уламжлалт маягийн зохиогчийн эрхийг нотлон тогтоох явц нь ээдрээтэй, бас цаг хугацаа их шаарддаг байлаа. Бидний судалгааны жишээнд илэрсэн Бээжингийн Шин Тү Чүн Лиян олон улсын технологийн хязгаарт компани нь эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүй бүтээлийн мэдээллийн хамааралтын эрх нь устгагдах буюу өөрчлөгдөх боломжтойг мэдсэн эсвэл мэдэх зохистой байдалд мөнхүү зөвшөөрөлгүйгээр мэдээллийн сүлжээг ашиглан олон нийтэд дамжуулан ашиг олсон байна. Хулгайн хэвлэлийн сүлжээний нийтлэлийн хурдац нь интернетийн цэгээс цэг хүрэх технологийн хүчээр асар хурдтай болсон нь уламжлалт маягийн эрх нотлон тогтоох явцын ач холбогдлыг харьцангуй болгожээ. Гэхдээ итгэмжит цагийн тамга (TSA) бол нэгэн зүйлийн цахим бичиг материалын (файл) буй болсон оновчтой цагийг гэрчилж чадах хуулийн хүчин бүхий цахим гэрч баримт мөн. Бас тоожуулсан зохиогчийн эрхийн өвөрмөц тэмдэг (Дижитал зохиогчийн эрхийн өвөрмөц танигч DCI) бол тоожуулсан бүтээлийн зохиогчийн эрхийг бүртгэх, зардлын тооцоохийх ба хяналт шинжилгээ хийж гэрч болгоход гол зориулалттай Үндэстний зохиогчийн эрхийг хамгаалах төвийн нийтийн үйлчилгээний ажил дахь шинэ үзэгдэл юм. Хурдан тархалттай хулгайн хэвлэлийн сүлжээний нийтлэлийн эсрэг арга хэмжээ авахад итгэмжит цагийн тамга (TSA) ба тоожуулсан зохиогчийн эрхийн өвөр-

мөц тэмдгийг (DCI) ашиглавал хэвлэлийн сүлжээний нийтлэл дэх зохиогчийн эрхийг хамгаалах ажил маш их үр дүнтэй болно. Энэ арга нь хурдан, амар хялбар бас хямд байдаг.

2. Хулгайн хэвлэлийг эсэргүүцэх боловсролыг олгох

Сингапурын оюуны өмчийн байгууллагын ерөнхийлөгч Лио Юань Раны бодлоор боловсрол олгох нь хулгайн хэвлэлтэй тэмцэх чухал арга юм. Мөн Тайваньд “Хулгайн хэвлэлийг эсэргүүцэх сурталчилгааны өдөр” гэж байдаг. Манай улсад “Сэлмэн сүлжээ” хэмээх тусгай арга хэмжээ явагдаж байсан бол 2014 оноос эхлэн өөрчлөгдөж, гол төлөв хулгайн хэвлэлийн сүлжээний нийтлэлийн эрх эзэмшигчийн хууль ёсны эрх ашгийг хүнд ноцтой хохируулсан эрх зөрчсөн ажиллагааг эсэргүүцэх болжээ. Үндэстний зохиогчийн эрхийн байгууллагаас ч жил бүр эрх зөрчсөн хулгайн хэвлэлийн 10 том хэргийг нийтэлдэг. Гэхдээ эдгээр нь муу жишээг олонд үзүүлж, эрх ашгийг хамгаалахын үүднээс сэдэгдсэн тэмцэх арга хэмжээ юм. Ийм арга хэмжээ бол шийтгэл ба эрх сүрийг ашиглан хулгайн хэвлэлийн ажиллагааг таслан зогсоодог. Харин хулгайн хэвлэлийг эсэргүүцэхэд засгийн зүгээс тэмцэх арга хэмжээг шаардлагатайгаар барахгүй түүнд интернет хэрэглэгчдэд системтэй, сонирхолтой боловсрол олгох арга хэмжээг багтаах шаардлагатай. Ингэснээр хэрэглэгчдийн хулгайн хэвлэлийг худалдаж авах нормыг доошлуулж болох юм. Өнөөгийн эрх зөрчсөн хулгайн хэвлэлд сүлжээний нийтлэл газар авсан цагт хулгайн хэвлэлийн тоглоом, хулгайн хэвлэлийн жигтэй бичлэгийг (Otokaimad) эсэргүүцсэн зэрэг сонирхолтой нийтлэлүүдийг олон зэргийн арга барилаар цацвал хүмүүс

сонирхох явц дунд аяндаа хулгайн хэвлэлийг эсэргүүцэх үзэл бодолтой болох юм.

3. Хууль цаазын системийг төгөлдөржүүлж зарчмуудыг хэрэглэх

Манай улсад зохиогчийн эрх зөрчсөн хариуцлагыг ослын хариуцлагын ёсоор шийдвэрлэдэг. Харин зохиогчийн эрх зөрчсөн хариуцлагын дотор нь зохиогчийн эрх шууд зөрчсөн ба зохиогчийн эрх дам зөрчсөн гэх хоёр төрөлд хуваадаг. Гэтэл “Зохиогчийн эрхийн хууль”-д зохиогчийн эрх дам зөрчсөн хариуцлагад системтэй тогтоол гаргаж чадаагүй байна. Тухайлбал, “Зохиогчийн эрхийн хууль”-д эрх зөрчсөн хариуцлага нь шүүгдэгч талын “зориуд” санааг голчилж үздэг байхад “ослын хариуцлага”-ыг үүнд хэрэглэвэл шүүгдэгчийн үйлдэл осол алдаа байх эсэхийг магадлахад хүндрэлтэй болгодог. Энэхүү асуудлыг хэрхэн шийдвэрлэх тухай зохиогчдын байр суурь нь зохиогчийн эрх шууд зөрчсөн байдалд “осолгүй хариуцлага”-ын зарчмыг хэрэглэн, зохиогчийн эрх дам зөрчсөн байдалд “ослын хариуцлага”-ын зарчмыг хэрэглэвэл “Зохиогчийн эрхийн хууль”-ийг төгөлдөржүүлэх болно. Анхуйн “Сү Жөгийн (9.27) сүлжээгээр хулгайн хэвлэлийн нийтлэл борлуулсан хэрэг”, Анхуйн “Тэн овогт зэрэг хүмүүс сүлжээний тоглоомын зохиогчийн эрх зөрчсөн хэрэг” дэх гол хариуцлагатанд нь бүр эрх шууд зөрчсөнд тооцогдох болохоор тэдэнд “осолгүй хариуцлага”-ыг хэрэглэвэл “Зохиогчийн эрхийн хууль”-ийг төгөлдөржүүлэхээс гадна хууль цаазын ажлын үр дүнг дээшлүүлэх болно.

Дүгнэлт

БНХАУ-д “хулгайн хэвлэл”-ийн хамаа бүхий сэдэвтэй судалгаа олон байдаг боловч “интернет нэмэх” цаг үе хийгээд

кейс судалгааны аргыг уялдуулан судалгаа хийсэн нь тус өгүүллийн судалгааны арга дахь шинэлэг тал юм. Ийм арга нь шинэ цаг үе дэх зохиогчийн эрх зөрчсөн хулгайн хэвлэлийн онцлог, буй болсон шалтгаан ба түүнийг хариуцан эсэргүүцэх аргыг шинээр тусгаж чадсан. Зохиогчийн бодлоор эл талын чармайлтын үр дүнд зохиогчийн эрхийг хэрэглэх нь яваандаа дүрэмжэхийн дагуу манай улс дахь эрх зөрчсөн хулгайн хэвлэл улам бага болох нь дамжиггүй.

Ишлэл

¹Мэдээллийн ирэлт: PR Newswire, Америкийн аж ахуйн сонин мэдээллийн компани

²http://photos.pnasia.com/fileman/static_file/do_view?permalink=20150307/0861501586

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Лиө Рэн. Жүн Гуан Сүний асуудал. Далай тэнгисийн хэвлэлийн хороо, 1996 оны 6-р сар. Анхны хэвлэл . х.208.
2. Ли На. Хулгайн хэвлэлийг эсэргүүцэх аргын судалгаа. Төв өмнөд их сургууль, 2002.
3. Яэ Янь Янь. Хулгайн хэвлэлийг сэргийлэх хууль цаазын асуудлын судалгаа Төв өмнөд их сургууль, 2012.
4. Хуан Ан Чи. Иргэн улсын үе дэх хуулмал хэвлэлийн номын үзэгдлийн судалгаа (1927-1937). Үү Хан их сургууль, 2017.
5. Жү Шо Хан. P2P технологийн орчин дахь сүлжээний үйлчилгээ үзүүлэгчийн зохиогчийн эрх зөрчсөн хариуцлагын тухай асуудлын судалгаа. Зүүн Хятадын улс төрийн шинжлэх ухаан хууль зүйн их сургууль, 2015.
6. Хэ Жэ Ли. Хулгайн хэвлэлийн асуудал ба хулгайн хэвлэлийг эсэргүүцэн хариуцах аргын тухай судалгаа // “Да Чингийн нийгмийн шинжлэх ухаан”, 2017, №03, х.106-108.
7. Ян Жи. Тоожуулсан цаг үед хэвлэл хулгайлах нь ялгүй юу? Сүлжээн дэх

эрх зөрчсөн 3 асуудлын тайлбар // "Технологи ба хэвлэл". 2017, № 05, х.81-85.

8. Жө Чэн Сэ. Сүлжээний хулгайн хэвлэлийн үзэгдэлд суурилан зохиогчийн эрхийг хамгаалах асуудлын тухай шинжлэх нь // "Хууль зүйн дэлхий". 2016, № 17, х.5-7.
9. Лян Түн Хүй, Юань Чин Жан, То Лэй. Интернетийн орчин дахь тоожуулсан хэвлэл нийтлэлийн хулгайн хэвлэлийн арга маяг ба түүний цэгцлэлтийн судалгаа. // "Технологи ба хэвлэл". 2014. №12, х.115-118.
10. Лю Яэ Лин. Манай улсын интернетийн зах дэлгүүр дэх голч бус өрсөлдөөний дүрмийн системийн шинийг үүдэлт - Дундад улсын сүлжээнийий видеогийн хулгайн хэвлэлийг эсэргүүцэх холбооноос Бай Дүг заалдсанаар жишээ болгох нь // Төв өмнөдийн ойн аж ахуйн технологийн их сургуулийн сонин/ Нийгмийн шинжлэх ухааны хэвлэл. 2014. № 8(06), х.77-81.

11. Цо Ван Жүн. Манай улс дахь хулгайн хэвлэлийн үзэгдлийн эдийн засгийн дүн шинжилгээ // "Дундад улсын зах дэлгүүр", 2017. № 03, х.44-45.

Резюме

Статья посвящена вопросам плагиата и нарушениям авторских прав в СМИ Китая, в том числе в Социал медиа. Авторы статьи опираясь на многочисленные факты из практики СМИ и Социал медиа делают вывод о том, что в последние годы нарушения авторских прав часто наблюдаются в южных районах Китая, что связано с интенсивным развитием экономики и новой информационной технологии в этих районах. Авторы статьи также отмечают о необходимости улучшения правовых актов, регулирующих вопросы, связанные с соблюдением авторских прав и других нарушений в деятельности СМИ страны.